

ЗОНХАВЫН “БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ” ДЭХ БЯСАЛГАЛЫН ТАЛААРХИ ҮЗЭЛ САНАА

О. Чимэг

МУИС, Шашин судлалын тэнхим

Түлхүүр үг: амарлин оршихуй, үлэмж үзэхүй, үзэгдэл үгүйн зөн, “дүрдээ орох”, “мэдрэмж”.

Товч утга: Судлаач богд лам, Зонхавын “Бодь мөрийн зэрэг” зохиол дахь бясалгалын эрдмийг хураасан амарлин оршихуй хийгээп үлэмж үзэхүйн сургаалийн үндсэн дээр түүний үзэл санаан дахь даяан бясалгалыг юмс үзэгдлийн мөн чанарыг таньж мэдэхэд чиглэгдсэн нийт хүнд байдаг сэтгэн бодох үйл ажиллагаагилэрхийлсэн ойлголт хэмээн дүгнэж, энэхүү үйл ажиллагааны үр рүү авч үзэн, ойлгон тайлбарлахыг оролдсон.

Дээрхи үйл ажиллагааг илэрхийлсэн “ агуулж бясалгах”, “шинжилж бясалгах” хийгээд “ үзэгдэл үгүйн зөн” хэмээх гурван “газар” буюу үе шатыг судлаач “сэтгэлийн дүр үүсгэж” мэдрэх, “дүрдээ орж” гүнзгийрэх үйл явц ба “дүр” гэх юм арилан үгүй болж, сэтгэхүйн аливаа үйл ажиллагаа зогссон ухаарал байдлаар тайлбарлалаа.

“Бодь мөрийн зэрэг” зохиолдоо богд Зонхав сүүлчийн хоёр барамид болох даяан, билгийг амарлин оршихуй ба үлэмж үзэхүйн тухай сургаалаар тусгайлан авч үзсэн нь бясалгалын эрдмийг багтаадагтай холбоотой юм.

Бясалгал гэдгийг гол төлөв даяанчидтай холбон үзэж, агуй зэрэг хүнгүй газар явуулдаг ямар нэг онцлог үйл ажиллагаа хэмээн ойлгох явдал түгээмэл байж ирсэн бол сүүлийн үед тархиа амраах, бие, сэтгэлийн эрүүл ахуйг төлөвшүүлэхэд чиглэгдсэн дасгал талаасаа өргөн дэлгэрч байна.

Бясалгалын эрдмийг илэрхийлсэн амарлин оршихуй ба үлэмж үзэхүйн тухай богд Зонхавын үзэл санаа нь юуны өмнө бурханы шашны мөн чанарыг судар номын ойлголт ухагдахуунаар ухаарах, улмаар нисванисаа “бие дор” илт дарах “бодит практик”-т чиглэгдсэн байдаг хэдий ч түүний үзэл санаан дахь даяан бясалгалыг юмс үзэгдлийн мөн чанарыг таньж мэдэхэд

чиглэгдсэн нийт хүнд байдаг сэтгэн бодох үйл ажиллагааг илэрхийлсэн ойлголт мөн гэсэн дүгнэлт хийж болохоор байна. /3/

Гэхдээ бусад шашин, философийн нэгэн адил ертөнцийг үзэх цогц үзэл болохынхоо хувьд бурханы шашин нь энэхүү үзлийнхээ үүднээс хувь хүний амьдралд хандах байр суурийг төлөвшүүлэхийг зорьж байсан учраас даяан бясалгал хэмээх сэтгэн бодох үйл ажиллагаа ч Бурхан багшийн амьдралын туршлага, ухаарлыг өөрийн нь номлол ба хожмын сэтгэгчдийн нарийвчлан боловсруулсан үзэл ойлголтуудаар судлан ухаарахад чиглэгдсэн байдаг.

Буддын философийн судар номын нэлээд хэсэг сэтгэн бодох энэхүү үйл ажиллагааг явуулах арга, эрэмбэ дарааг тусгасан байдаг билээ. Аливаа юмыг өөрийн болтол ойлгож ухаарах гол нөхцөл болсон сэтгэн бодох үйл ажиллагааг дэлхийн шашнуудын дотроос хамгийн эртнийх нь болох буддын шашинд тусгайлан авч үзэж, онцгой туршлага хуримтлуулсан нь Энэтхэгийн олон зууны уламжлалаас гадна бурхан болж гэгээрэх энэхүү шашны өөрийн нь зорилготой холбоотой юм.

Нөгөө талаар бурханы шашны бясалгал явуулах тусгайлсан үйл ажиллагаа юуны өмнө хоосон чанарыг оноход зориулагддаг байсан учраас хоосон чанарын талаархи ойлголтын ялгаа зэргээс хамаарч бясалгах арга барил адилгүй, зарим чиглэлийг ялгах онцлог ч үүнтэй холбоотой байсан нь “Бодь мөрийн зэрэг”-т тусгагджээ.

“Бодь мөрийн зэрэг”-ийн хувьд бясалгалын үйл ажиллагаа нь бурханы шашны уламжлалт үзлийг “өөрийн болтол” ухаарахад чиглэгдэж байсан нь зохиолын үзэл санаанаас харагддаг. Дашрамд тэмдэглэхэд өгүүлэн буй зохиолд хоосон чанарыг оноход зориулагдсан бясалгалын талаар адилгүй үзэл ойлголтууд байдгийг Энэтхэг, Хятадын зарим сэтгэгчдийн жишээн дээр авч үзсэн байдаг. Богд Зонхавын бурууд үзсэн дээрхи сэтгэгчдийн дотор нэрлэгдсэн Хятадад өргөн дэлгэрсэн арга гэдэг нь Чань Буддизм бололтой байдгийг энд цухас дурдая.

Бясалгалын үйл ажиллагааг тусгайлан явуулж буй хүнийг егүзэр гэх

бөгөөд “Бодь мөрийн зэрэг”-т ч “... тэр ямагт чанарыг бясалгагч бээр үйлдэх хэрэгтэй тул егүзэр бээр хэмээн номлов” /1,119а – 1976/ гэжээ.

Оюун ухаандаа бодож шинжлэх танин мэдэхүйн энэхүү үйл ажиллагааны үр дүн, онцлогийг богд Зонхав: “Тэнцэл үгүй зөн дор нь “Билиг барамидын увдис”-наас: “Өөрийн сэтгэлийг шинжилвээс бүхэн ном өөрийн сэтгэл дор оршму”. “Энэ ном огторгуйн очир дор оршму. Ном хийгээд номын чанар үгүй болой” хэмээн “Нууц хураангуйгаас” номлосноор ч “Ланка дор ажирсан”-аас: “Сэтгэл төдийхөн дор шүтэж гадаад утга дор үл шинжлэх болой...” /1, 213а/ гэсэн үгээр илэрхийлжээ. Энэ үйл ажиллагаа:

1. Сэтгэлийн төдий дор зорихуй
2. Түүнчлэнхүү чанар дор зорихуй
3. Үзэгдэл үгүйн зөн

гэсэн гурван “газар” буюу үе шаттай. Үүнээс “анхны хоёр газар дор агуулж бясалгахуй хийгээд шинжилж бясалгахуй бээр амарлин үлэмжийг бүтээдэг” /1, 212б – 213а/ бол “үзэгдэл үгүйн зөн” хэмээх гуравдах газар бясалгалын эцсийн үр дүнг илэрхийлнэ.

Амарлин үлэмжийн бодит нь танин мэдэхүйн өндөр түвшинд хүрэх, хутагтан болох ухаарлын өндөр түвшинд хамаарах ойлголт боловч амарлин оршихуй хийгээд үлэмж үзэхүй нь хүний оюун сэтгэхүйн аливаа үйл ажиллагаа агуулж бясалгахад шүтэж, шинжилж бясалгадаг онцлогийг нь, харин бэлгэ үгүйн зөн, үзэгдэл үгүйн зөн зэрэг ойлголтууд бясалгалын эцэст хүрэх “мэдлийг” илэрхийлдэг гэж үзэж болмоор байна.

Агуулж бясалгах хийгээд шинжилж бясалгах

Зохиолын үзэл санаагаар бясалгана гэдэг нь зорилгоо болгосон, бодох гэж байгаа юмаа сэтгэлдээ тогтоон, түүнийхээ талаар бодож шинжлэх буюу сэтгэлдээ үйлдэх үйл ажиллагаа бөгөөд юмсыг агуулж бясалгах, шинжилж бясалгах хоёр үе шаттай. Агуулж бясалгана гэдэг нь бясалгах юмаа нүдний мэдлээр харж ажиглах бус, харин дотоод сэтгэлдээ дүрийг нь ургуулах, шинжилж бясалгах нь сэтгэлдээ ургуулсан дүрээ билгээр задлан шинжилэхийн нэр юм.

Богд Зонхав "их, бага хөлгөний ертөнц ба ертөнцөөс нөхцсөн хамаг эрдэм амарлин үлэмжийн үр мөн" хэмээн "Тааллын тайлбар"-т номлосныг "амарлин үлэмж нь бясалгаснаас болсныг олсон сэтгэлийн эрдэм бус буюу. Тэдгээр эрдэм бүгд тэр хоёрын үр" /1, 136 а/ хэмээн амарлин үлэмж нь бясалгасны эцэст олдог эрдэм бус, харин сэтгэлийн бүх эрдэм энэ хоёрын үр дүнд төрдөг бөгөөд амарлин үлэмж хоёр нь бясалгалын эрдмийг бүхэлд нь агуулдгийг тайлбарлан хэлжээ. Ерөөс бодож бясалгах үйл явц бүхэлдээ амарлин үлэмжийн зүг дор хурах тул их, бага хөлгөний хамаг эрдмийг амарлин үлэмжийн үр гэж үзэхгүй ч буяны зорилго дор нэгэн үзүүрт сэтгэлээс дээш самади бүхнийг амарлин оршихуйн зүг дор, харин ямар мэт, хэдүй бүхний утгыг тус тус дор ялгагч билгийн буян бүхнийг үлэмж үзэхүйн зүг дор хурах утгаар гурван хөлгөний эрдмийг амарлин үлэмжийн үр гэж үзэхэд ч харшлах зүйл үгүй ажээ. /1, 136а – 136б/

Амарлин оршихуй

Амарлин оршихуйн мөн чанарыг Зонхав "бодит амарлин оршихуй" нь "Тааллын тайлбар"-аас: "гагцаар аглаг дор сууж дотроо үнэхээр агуулаад ямарваа сэтгэсэн тэдгээр номыг сэтгэл дор үйлдээд сэтгэл алин бээр сэтгэл дор үйлдэхийн тэр сэтгэлийг дотроо үргэлж тогтоогоод сэтгэл дор үйлдэхүй бээр сэтгэл дор үйлдэх болой. Тэр мэт ороод түүн дор олонтаа оршсон түүний бие маш судалсан хийгээд сэтгэл маш судалсан болох алин буй нь амарлин оршихуй хэмээгдэх буюу хэмээн номлоод түүний утгыг бусад дор алгасалгүй үргэлж тогтоон сэтгэл дор үйлдсэнээр сэтгэл зорилго дор өөрөө аяндаа орших буюу. Бие сэтгэл маш судалсан баяр амгалан төрвөөс тэр самади амарлин оршихуй болох буюу" /1, 136б/ хэмээн тодорхойлсон байдаг.

Агуулж бясалгах замаар бүтээдэг амарлин оршихуйн тухай богд Зонхавын үзэл санаагаар амарлин оршихуй гэдэг нь гадаад орон дор үл алгасан, сэтгэлийн зорилго дор төвлөрөхийн нэр. Сэтгэсэн юмаа сэтгэлдээ тогтоож бүрэн төвлөрөхийн тулд зорилгоосоо бусад зүйлд анхаарлаа сарниулахгүй, гагцхүү бодох гэсэн зорилгоо "агуулах" бөгөөд бүрэн төвлөрч

сурахад чиглэгдсэн дасгалууд болон энэхүү төвлөрлийн үе шатуудыг самадийн таван гэм, сэтгэл оршихуйн есөн зэрэг, сэтгэлээр үйлдэхүй дөрөв зэрэг ойлголтууд илэрхийлдэг. /3/

Богд Зонхав “ Гадаад орон дор тийн бөгөөд алгасахыг амарлиулж дотоод зорилго дор үргэлж өөрийн эрхгүй бээр орохуй дор баясахуй хийгээд маш судалсан лугаа төгссөн сэтгэл дор оршигч нь амарлин оршихуй хэмээгдэх болой”. /1, 152а/ гэж тодорхойлсон байна. Сэтгэсэн юмаа сэтгэл дотроо агуулан тогтоож, зорилго болгосон зүйлээ байнга сэтгэлдээ бодож дадсанаар сэтгэл тэр зорилгодоо өөрөө аяндаа оршдог болох бөгөөд бие сэтгэл маш судалсан байдалд хүрсэнээр бодит амарлин оршихуй бүтэх ажээ.

Амарлин оршихуйг байнга сэтгэлд ороод байдаг, санаанаас гарч өгдөггүй юмтай зүйрлэж болох юм. Энэ нөхцөлд шинжилж эрэгцүүлэн бодох үйл ажиллагаа явагдахгүй.

“Бодь мөрийн зэрэг” дэх амарлин оршихуйн тухай богд Зонхавын үзэл санаанд тулгуурлан агуулж бясалгах хэмээгдэх сэтгэн бодох үйл ажиллагааны эхний, тулгуур үеийн тухай дараах дүгнэлт гарч ирж байна:

1. Сэтгэн бодох үйл ажиллагаа бол юуны өмнө *сэтгэлийн дүр үүсгэх* үйл ажиллагаа. Богд Зонхав “гэтэлгэгч Майдар бээр ч номын нэрийг боосон үүнийг амарлин оршихуйн мөр дор мэдтүгэй” /1, 137б/ гэж тодорхойлсныг бясалгах цагт нэр томъёог бус, харин нэр томъёогоор илрэх юмсын дүрийг сэтгэлдээ ургуулахыг хэлсэн хэрэг хэмээн ойлгож байна. Дор гарах үлэмж үзэхүйг тодорхойлсон хэсэг дэх “сэтгэлийн дүр бээр тэвчиж” гэсэн хэллэг ийм ойлголт зөв болохыг гэрчлэх мэт.

2. Санаандаа “агуулж” бясалгах явцад үүсэх энэхүү сэтгэлийн дүрийг түүний талаархи *мэдрэмж* дагалдана. “Тааллын тайлбар” зохиолоос авсан дээрх эшлэлийн “ямарваа сэтгэсэн тэдгээр номыг сэтгэл дор үйлдээд сэтгэл алин бээр сэтгэл дор үйлдэхийн тэр сэтгэлийг дотроо үргэлж тогтоогоод” гэсэн хэсгийн “сэтгэл алин бээр” гэдэг нь сэтгэлийн дүрийг “мэдрэмж” дагалдахыг гэрчлэх мэт.

3. Удаан хугацаанд бясалгаж дадсан дүрийг байнга сэтгэлд ороод байдаг, санаанаас гарч өгдөггүй юмтай зүйрлэж болох юм. Гэвч агуулж бясалгах үед шинжилж эргэцүүлэн бодох үйл ажиллагаа явагдахгүй.

Үлэмж үзэхүй

Үлэмж үзэхүйн мөн чанарыг Зонхав “үлэмж үзэхүйн бодит нь тэр судраас: “тэр бие маш судалсан түүнийг олж түүн дор оршоод сэтгэлийн дүр бээр тэвчиж ямарваа сэтгэсэн тэдгээр номыг дотроо самадийн явдал орон өнгө хөрөг дор тус тус дор онон үйлдээд бишрэн үйлдэх болой. Тэр самадийн явдлын орон өнгө хөрөг тэдгээр дор мэдэгдэхүүний утга түүнийг тийн бөгөөд ялгагч хийгээд маш тийн бөгөөд ялгагч ба огоот атгаглагч хийгээд огоод шинжлэхүй ба хүлцэнгүй хийгээд хүсэх ба өвөрмөц ялгагч хийгээд үзэл ба тийн бөгөөд атгаглагч алин буй тэр нь үлэмж үзэхүй хэмээгдэх буюу” /1, 137а/ хэмээн тодорхойлжээ.

Үлэмж үзэхүй бол бодож буй юмаа сэтгэл дотроо тогтоосон амарлин оршихуй дор оршсон цагт утгыг нь шинжлэх явдал юм /1, 137б/. Энэ нь урьд үүсгэсэн дүрээ тал талаас нь нарийвчлан шинжлэх үндсэн дээр гүйцэд ухаарахад чиглэгдсэн үйл ажиллагаа юм.

Үлэмж үзэхүйн тухай богд Зонхавын үзэл санаанд тулгуурлан шинжилж бясалгах үйл ажиллагаанд дүгнэлт хийвэл:

1. Шинжилж бясалгах үйл ажиллагаа нь урьд үүсгэсэн дүрээ тал бүрээс нь шинжлэх үндсэн дээр “дүрдээ орох” үйл ажиллагаа юм. Бурханы шашин, философитой нэлээд хэмжээнд холбоотой байдаг тулааны урлагийн зохиол бүтээлийг үзэхэд муур зэрэг амьтны “дүрд орох” дасгал буюу нэг ёсны “шид бүтээл” мөн л иймэрхүү дүгнэлт хийхэд хүргэдэг.

2. “Дүрдээ орох” арга хэрэгсэл нь “үзэл” юм. Үлэмж үзэхүйн “үзлийн” хэсэг нь бодгаль ба бодгалийн би үгүй, ном ба номын би үгүй болон инагуухи ба үнэмлэхүй үнэнийг нотлон буулгахад зориулагдсан байдаг билээ.

3. Шинжилж бясалгахуйн үр дүнд хүрэх ухаарал мөн л тодорхой “мэдрэмжээр” илрэх бөгөөд “мэдрэмж” утгаараа тэр бүр “үгээр”

илэрхийлэхийн аргагүй байдаг.

Хүн өөрийн сэтгэн бодох үйл ажиллагаандаа ажиглалт хийгээд үзэхэд ч "үнэхээр ойлгоно" гэдэг бол юуны өмнө тодорхой мэдрэмжээр илэрдэг зүйл. Энэхүү мэдэрч ойлгосон зүйлээ хүнтэй хуваалцахын тулд үгээр илэрхийлэх нь дараагийн шатны үйл ажиллагаа байдаг бөгөөд бясалгаж ойлгосон зүйлээ хүн "өөрийн үгээр" илэрхийлдэг. "Өөрийн үг" гэж хэлэх нь мэдээжийн хэрэг хэрэглээнд байдаг үгийг хэлэх учир харьцангуй ойлголт л доо. Гэхдээ энд хүний үгийг хуулах ба хүний үгнээс ойлгосон зүйлийг өөрийн болтол ойлгож илэрхийлэхийн ялгааг хэлж байгаа юм.

Жишээ болгоход "хэл, сэтгэхүй хоёр холбоотой" тухай марксист философийн онолын баримтлалыг "ярианы чадвар муутай бол сэтгэхүйн хувьд дорой" гэх маягаар дэндүү хялбаршуулж ойлгох явдал байдаг байсан. Энэ нь бусдаас сонссоноо ярих /мөн бичих/ ба өөрөө бодож ойлгосноо бусдад дамжуулахыг оролдон "үгээ эрж олж ядаж буй" үйл ажиллагааг эс ялгасан хэрэг юм.

Амарлин оршихуй ба үлэмж үзэхүйн талаархи Зонхавын сургаалиас бясалгал гэж юу болох, агуулж бясалгах хийгээл шинжилж бясалгах дарааллын талаар дүгнэлт хийвэл:

Бясалгал бол сэтгэлийн мэдэл төрүүлэх сэтгэн бодох үйл ажиллагаа. Сэтгэн бодох энэхүү үйл ажиллагаа нь гадаад ертөнцийг ажиглан харах бус, сэтгэл дотроо бодож буй юмсын дүрийг ургуулах үндсэн дээр явагддаг тухай "самадийг нүдний мэдлээр бус сэтгэлийн мэдлээр төрүүлнэ" гэсэн Зонхавын үгийг дурдахын дашрамд түүний шүүмжилсэн зарим үзлүүдийн тухай энд үл өгүүлэн "мод, чулуу" гөлөрч хоосон чанарыг онох тухай үзлийг буруушаасан байдгийг дурдая.

Сэтгэн бодох энэ үйл ажиллагаа яаж явагддаг тухайд энэ нь бодож буй юмсынхаа дүрийг үүсгэж мэдэрсний үндсэн дээр утгыг нь шинжилж тэрхүү мэдрэмжээ улам гүнзгийрүүлж "дүрдээ орох" байдлаар үргэлжлэнэ. Энд богд Зонхавын эш татсан гэтэлгэгч Майдарын үгийг бүхэлд нь дурдвал: "гэтэлгэгч Майдар бээр ч номын нэрийг боосон үүнийг амарлин оршихуйн

мөр дор мэдтүгэй. Үлэмж үзэхүйн мөр нь түүний утга нугуудыг тийн бөгөөд шинжлэгч хэмээн мэдтүгэй хэмээсэн хийгээд үнэхээр оршсон дор шүтэж сэтгэл дор сэтгэлийг агуулахын тул хийгээд номыг маш тийн бөгөөд ялгахын тул амарлин оршихуйн хийгээд үлэмж үзэхүй буй хэмээн үнэхээрийн самади дор шүтэж сэтгэл агуулагч амарлин оршихуйн хийгээд номыг маш тийн бөгөөд ялгагч билгийг үлэмж үзэхүй хэмээн номлов" (1,137а-137б) хэмээжээ.

Дарааллын хувьд эхлээд амарлин оршихуйг эрж, тэндээс үлэмж үзэхүйг бясалгадаг боловч энэ хоёр нь бодож буй юмсынхаа дүрийг ургуулан санаандаа тогтоон барьж, тогтоон барьсан юмныхаа талаар олон талаас нь бодож шинжлэх нягт холбоотой үйл ажиллагаа бөгөөд бясалгах зорилгын хувьд ч ялгаагүй байдаг. "Амарлин оршихуйд шүтэж үлэмж үзэхүй" үүсэх гол онцлог үүнд байгаа юм.

Тэгвэл "хоосон чанарыг оносон амарлин оршихуй ч буй бөгөөд хоосон чанарыг эс оносон үлэмж үзэхүй бээр буй болой" /1, 137б/ гэдгийг хэрхэн ойлгох тухай, мөн түүнчлэн "заримууд үлэмж үзэхүйг олсон, амарлин оршихуйг эс олсон буюу. Тэр үлэмж үзэхүй дор шүтэж, амарлин оршихуй дор хичээн үйлдэх болой хэмээн номлосон ямар буй" /1, 141а/ тухай асуултыг богд Зонхав зохиолдоо тавьжээ. Асуултын гол энд "амарлин оршихуйд шүтэж" үүсдэг үлэмж үзэхүй нь дарааллын хувьд эхэнд нь яригдаж байгаатай холбоотой юм.

Энэ асуултанд хариулахдаа богд Зонхав "эл тэр нь анхны даяаны бодитоос дээшийн амарлин оршихуйг эс ялгасан буюу. Тэр ч дөрвөн үнэнийг илт онож түүн дор шүтэж анхны даяанаас дээшийн амарлин оршихуйг бүтээх буюу" /1, 141/ хэмээжээ.

Үүнээс үзэхэд амарлин оршихуй гэдэг нь нэг талаар сэтгэлээ зорилго дор тогтоон санаж, үлгэрлэж хэлбэл дүрээ ургуулан тогтоохын нэр мөн хэдий ч нөгөө талаар шинжилж бясалгасны эцэст буюу үлэмж үзэхүйн үр дүнд юмсын утгыг ухаарч амарлисан байдал юм.

Үлэмж үзэхүйн хувьд бол энэ нь сэтгэлдээ агуулсан дүрээ "үзлээр" шинжилж, шинжилсэний үр дүнд олох үлэмж их ухаарал мөн хэдий ч заавал

хоосон чанарын үлэмж үзэхүй байх албагүй, түүнээс доошхи шатны ухаарал байж болох ажээ.

Дээрхи тайлбараа зөв гэж бодож буй үндэслэл гэвэл богд Зонхавын "хоосон чанар дор зорьсон самади хийгээд билиг мөн, бус нь орон хоёр би үгүй алин болохыг тэр оюунаар оносон, эс оносны үүднээс танин барих хэрэгтэй" (1,138а), өөрөөр хэлбэл хоосон чанарыг зорьсон самади хийгээд билиг мөн, бус нь юу бясалгаж байгаагаас шалтгаална гэсэн санаа бөгөөд амарлин оршихуйд шүтэж, бясалгаснаас болсон үлэмж үзэхүйг үүсгэнэ гэдэг нь чухамдаа *би үгүйг сэтгэлдээ бясалгаж ухаарахын* нэр юм.

Өөрөөр хэлбэл бодож шинжилсэний эцэст хүрэх аливаа ухаарал сэтгэлийн дүрд шүтэж хуримтлуулсан мэдлэгийн үндсэн дээр шинжлэх үйл ажиллагаа бөгөөд "амарлин оршихуйд шүтэж шинжилж бясалгах" учиртай. Харин "үлэмж үзэхүй дор шүтэж амарлин оршихуй дор хичээн үйлдэх" тухайд урьдах шатны бясалгалын зорилго болсон үлэмж үзэхүйг олсондоо шүтэж "анхны даяаны бодитоос дээшхи" зорилгод чиглэсэн сэтгэлийн дүр ургуулж, түүндээ "орох" үйл ажиллагаа юм.

Бясалгал хийх ерөнхий зарчмын хувьд бясалгах үзэл ойлголт нь улам гүнзгийрэх хэдий ч аль ч түвшинд агуулж бясалгахад шүтэж, шинжилж бясалгах буюу амарлин оршихуй бүтээн үйлдэж хойно нь үлэмж үзэхүйг бясалгах зарчмаар явагдах бөгөөд үүнийг ч "Гэтэлгэгчийн гол" хийгээд "Бодьсадвагийн газар" хийгээд "Ширваангийн газар" ба төгс сайн ялгагч хийгээд Шантидева ба Камалашилагийн гурван зэрэг хийгээд "Билиг барамидын увдис" тэргүүтэн олон голоос номложээ (1,211б-212а).

Үзэгдэл үгүйн зөн

Бясалгалын эрдмийг бүхэлд нь хураасан амарлин оршихуй ба үлэмж үзэхүй хоёр нь буддын шашны ёсоор бурхан болж гэгээрэхэд чиглэгджээ. "Үзэгдэл үгүйн зөн" хэмээх гуравдах "газар" нь бясалгалын эцсийн үр дүнг илэрхийлсэн ойлголт юм.

Өгүүлэн буй гурван газраар илрэх тэнцэлгүй зөнгийн хувьд энэ нь тарнийн аймагт хамаарах ойлголт. Богд Зонхавын "Бодь мөрийн зэрэг"-т

тарнийн бясалгалын тухайд үүсгэлийн зэрэг ба төгсгөлийн зэрэг гэсэн хоёр ялгалын тухай голлон дурдсан байдаг ба "Бодь мөрийн зэрэг" нь үүсгэлийн зэрэгт хамаарах хэдий ч "гадаадтан хийгээд дотоодтон ба их, бага хөлгөн хийгээд их хөлгөний хоёр зүйлтэн ба үндэсний аймаг дээд, доодын хоёр зүйл зэрэг ямагтын үе дор төрөхийн ерийн самадийг маш тодорхойяа олон мэргэдийн голчлонхүү олон сайн номлол бээр зөнг эрхлэн авахын одох мөрийн эндүүрэлт газрыг сайтар онох болохын бодь мөрийн зэргийг хураасан үүнийг онц тонилохуйг хүсэгч нүгүүдийн тул жич найруулсан" /1, 2226/ тухайгаа зохиолын эцэст өгүүлсэн байна.

"Үзэгдэл үгүйн зөн"-гийн тухай "Бодь мөрийн зэрэг"-т тусгайлан өгүүлээгүй хэдий ч бүх юмсын мөн чанарыг танин мэдэх дээд түвшингийн тухай, үнэмлэхүй үнэний тухай хэсэгт тодорхой тусгагдсан байдаг. Үнэмлэхүй үнэнийг олох, ямагт чанарыг онох үеийн тухай "юуг ч эс үзсэн дор тэр ямагт чанарыг үзэв" (1,203 б), "тэр ямагт чанарыг онохуй дор агуулахуй нь томъёоны мэдлийн төдийхөн дор агуулму. Бэлгэ билиг түүний хувьд үл агуулахын утга мөн" (1, 2056) гэх зэргээр өгүүлсэн нь бүх юмсын мөн чанарыг танин мэдэх нь "томъёоны мэдлийн үүднээс бүхнийг агуулах маягаар яригдаж буй хэдий ч уг чанартаа юмс үзэгдэл юуг ч эс үзэх, юуг ч эс агуулах байдал ажээ.

Үнэмлэхүй үнэнийг олж бурхан болох цагт энэхүү үнэмлэхүй үнэний "мэдэл" ямар нэгэн дүр буюу үг, хэллэгээр үл илрэх төдийгүй "юуг ч эс үзсэний ёсоор үзнэ". "Бодь мөрийн зэрэг"-т: "бурханы ямар мэтийг айлдагч бэлгэ билгээр үнэмлэхүй үнэнийг олох бөгөөс "Орохуйн" тайлбараас: дүр тэр мэтийн чанарыг үзсэн үгүй биш үү? Тиймийн тул ямарваа тэдгээрийг бээр үзмүй хэмээвээс үнэн буй за тийм боловч эс үзсэний ёсоор тэдгээрийг үзсэн болой хэмээн өгүүлэх болой хэмээн юуг ч эс үзсэн дор тэр ямагт чанарыг үзэв хэмээн номлоод түүнийг мэдүүлэх дор үнэмлэхүй үнэн, хамгийг айлдагч бэлгэ билгийн орноос ч хэтрэв хэмээн номлол лугаа татсан хийгээд бурханы газар дор сэтгэл, сэтгэлээс гарсны гүйдэл ашид урвасан дор номлосон хийгээд бурхан бээр цогц тэргүүтнийг эс үзвээс арван хүчний

үе дор хамаг номыг айлдах хэмээн номлосон луга ямар мэт үл харшилму хэмээвээс эс үзсэний ёс бээр үзэв хэмээсэн нь орон алин буй бүгдийг эс үзсэн дор үл үйлдмү. Мунхагийн бүрэлзэхүйн хүчээр зорьсон энэ нүгүүд тэр ямагт чанар дор буй бөгөөс хутагтаны тэгш агуулсан цуврилгүй бэлгэ билгээр зорих хэрэгтэй бөгөөтөл тэр нүгүүд юуг ч эс үзсэний үүднээс тэдгээрийн тэр ямагт чанарыг үзсэн дор үзүүлсэн мөн буюу. Түрдгэгдэхүүн буй бөгөөс зорилго дор болох бөгөөтөл үл зоригдохын тул түрдгэгдэхүүн хоосон нь онов хэмээн агуулахын тул болой. Үзсэн үгүй нь үзсэний дээд болой хэмээн номлосны утгыг ч түүнчлэн мэдтүгэй. Тэр мэтийг ч "Хураангуйгаас": "өнгө нүгүүдийг үл үзэн, мэдэхүй нүгүүдийг үл үзэн, мэдрэхүй нүгүүдийг ч үл үзээд хуран мэдэхүйг үзэхүй үгүй бөгөөд сэтгэхүйг үл үзэн алин дор танин мэдэхүй хийгээд сэтгэхүй сэтгэлийг үзэхүй үгүй нь номыг үзсэн мөн хэмээн түүнчлэн ирсэн бээр үзүүлэв" (1,203 а-203 б) гэжээ. Үүгээр бясалгалын эцсийн үр дүн болсон илт мэдэл, зөнг харуулсан байна.

Үлэмж үзэхүйг бясалгах үед "үзэлд" тулгуурлан сэтгэлийн дүрээ "тэвчин" шинжилж тунгаадаг, харин тунгааж эзэмшсэн цагт тэрхүү "дүрдээ" нэвт шингэж "дүр" гэх юм арилж үгүй болно. Үүнийг илт онох, "бие дор илт болгох" хэмээх ажээ.

"Бодь мөрийн зэрэг"-тээ хоёр үнэний тухай болон үнэмлэхүй үнэний ялгалын тухай нарийвчлан авч үзсэн байдаг богд Зонхавын өгүүлсэн зүйлээс үзэхэд бодит үнэмлэхүй үнэн нь "мэдэгдэхүүн бус" /1, 2076/ буюу үг, хэллэгээр үл илэрхийлэгдэх, сэтгэхүйн аливаа үйл ажиллагаа зогссон ухаарлыг илэрхийлэх бөгөөд "үнэмлэхүй" утгаар нь хүний амьдралын туйл болох үхэлтэй давхцах ойлголт юм. "Бурхан болсон" хэмээн үхлийг хэлдэг ойлголт ч үүнтэй холбоотой болов уу. /3/

Үнэмлэхүй үнэн буюу гүн ухаарлын агшнууд амьдралын явцад тохиолдох бөгөөд "Илт онохуйн чимэг" болон "Далан утгат" зохиолууд дахь нэгэн агшны найруулгын тухай ойлголт бясалгаж, "бие дор илт болсон" "сэтгэлийн зөнгийн эцэс"-ийн агшнуудыг илэрхийлдэг болов уу. /2, 3а-3б, 196-206/

Summary

The author of the article considers Tsonkapa's views on yoga practice, summarized as the teaching about tranquility and extraordinary vision in his "Grades on the path to Bodhi", and interprets it as reflecting process inherent in all persons.

Considering three stages of meditation process, mentioned in Tsonkapa's work "namely "concentrating in mind" and "concentrating on Suchness", when yogi is absorbed in his "aim", and "intuition without phenomenon" as the result of the meditation process, the author of the article interprets the first stage of "concentrating in mind" or "absorption in the aim" as the stage of creating of an image of the object of mind, accompanied by a feeling of that object, and the second stage of analyzing the object on the base of "views" as a process of "entering into the object of mind," when deepening of the object's feeling comes about.

The result of meditation process, which might be presented, as the author thinks, by some parts of the work on absolute truth, is interpreted as "complete entry into the image of the object", confluence with it, stoppage of all mind activities.

Ном зохиол

1. а) Лувсандагва (Зонхав). Гурван төрөлхтний анхааран авах бодь мөрийн зэрэг оршвой. Бээжин бар (Төвд хэл дээр). Цаасны хэмжээ 49.5x9.5. Барын хэмжээ 27x6. Мөрийн тоо 5. Хуудасны тоо 223 (Эшлэлийг энэ номоор заав).

б) Лувсандагва (Зонхав), Бага бодь мөрийн зэрэг оршив. Төвдийн Молом равжамба хийгээд Монголын гүүш Наганзуна Жүдва аягаа тахимлиг нарын монгол орчуулгаас хийсэн гар бичмэл (эшлэлүүдэд энэ орчуулгыг голлон тулгуурлав).

2. Гончогжигмэдванбу "Найман бод, далан утгын тийн ялгалыг сайтар номлосон Майдар ламын эш хэмээхүй оршвой" /төвд бар/. Цаасны хэмжээ 60,5 x 10. Барын хэмжээ 55,5 x 8. Мөрийн тоо 7. Хуудасны тоо 22

3. О. Чимэг. Бясалгал буюу танин мэдэхүйн цөм. - Зонхавын "Бодь мөрийн зэрэг"дэх нийгмийн философийн үзэл санаа Философийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон бүтээлийн 2-р бүлэг. УБ 2001